



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/250

Арвайхээр

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшигч иргэдийн гаргасан хүсэлтийн дагуу Арвайхээр сумын 5 дугаар багийн Шинэ Арвайхээрийн 4 дүгээр гудамжны 422 тоотод байрлах Пүрэвийн Загарзүсэмийн (У367042914) эзэмшлийн үйлдвэрлэлийн зориулалттай 2800м² газрыг Дэлхийн хүнс ХХК-д (3565084) зориулалтын дагуу 7 жил 1 сарын хугацаатайгаар газар эзэмших эрхийг шилжүүлсүгэй.

2. Дээрх газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуйн нэгжтэй холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон, газрын улсын бүртгэлд бүртгэн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай 2018 оны а/377 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100583